

БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын 3 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/046/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Баян жанжин хишиг аудит
ХХК-ийн туслах аудитор: Г.Тунгалаг
Утас: 88082716, Цахим хаяг: baynjanjinxishig@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Дүгнэлтийн үндэслэл	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026-01-29 №УВА-2026/046/Н.А-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

УЛААНГОМ СУМЫН 3 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д. ДЭЖИДМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын 3 дугаар Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Улаангом сумын 3 дугаар Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх матриаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсон санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050286

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	344,844,776.03	175,771,583.32
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	207,556,566.03	23,942,302.03
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	207,556,566.03	23,942,302.03
3121	Төгрөг	207,556,566.03	23,942,302.03
31211	Төрийн сангийн харилцах	207,556,566.03	23,942,302.03
35	БАРАА МАТЕРИАЛ	137,288,210.00	151,829,281.29
354	Хангамжийн материал	137,288,210.00	151,829,281.29
35410	Бичиг хэргийн материал	1,320,150.00	904,800.00
35420	Аж ахуйн материал	266,000.00	148,000.00
35460	Хүнсний материал	3,431,120.00	2,042,800.00
35470	Бусад хангамжийн материал	132,270,940.00	148,733,681.29
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,417,015,546.97	1,345,756,373.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,417,015,546.97	1,345,756,373.30
392	Биет хөрөнгө	1,314,233,741.41	1,243,038,734.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,418,118,482.00	1,418,118,482.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-229,892,389.09	-269,198,296.21
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	115,510,101.00	124,189,101.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-48,997,205.18	-77,259,938.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,034,159.38	65,465,959.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,170,232.43	-28,147,399.22
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,420,000.00	7,420,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-301,583.32	-2,111,083.24
39217	Ном	4,512,409.05	4,561,909.05
393	Биет бус хөрөнгө	102,781,805.56	102,717,638.92
39301	Програм хангамж	192,500.00	192,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-10,694.44	-74,861.08
39303	Бусад биет бус хөрөнгө	102,600,000.00	102,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,761,860,323.00	1,521,527,956.62
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,225,705.69
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,225,705.69
413	Өглөг	00.00	2,225,705.69
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,603,387.94
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	622,317.75
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,761,860,323.00	1,519,302,250.93
51	Засгийн газрын хувь оролцоо	1,761,860,323.00	1,519,302,250.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	311,631,897.80	311,631,897.80
51101	Өмч: - төрийн	311,631,897.80	311,631,897.80
512	Хуримтлагдсан үр дүн	904,718,961.95	662,351,681.88

51210	Өмнөх үеийн үр дүн	904,718,961.95	904,909,753.95
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-242,558,072.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	545,509,463.25	545,318,671.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,761,860,323.00	1,521,527,956.62

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,603,564,694.00	1,360,251,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,806,894.00	11,995,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	47,806,894.00	11,995,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,555,757,800.00	1,348,256,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,402,243,900.00	1,195,253,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,402,243,900.00	1,195,253,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	153,513,900.00	153,002,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	153,513,900.00	153,002,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,435,144,998.06	1,602,809,372.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,435,144,998.06	1,602,809,372.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,382,492,221.72	1,589,222,972.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	910,185,086.00	1,042,737,277.00
210101	Үндсэн цалин	555,640,888.00	641,528,731.00
210102	Нэмэгдэл	294,115,124.00	313,809,251.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,199,610.00	42,204,596.00
210104	Урамшуулал	51,229,464.00	45,194,699.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,022,848.00	131,354,987.94
210201	Тэтгэврийн даатгал	79,403,529.00	89,624,987.94
210202	Тэтгэмжийн даатгал	9,351,204.00	10,432,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,546,871.00	5,216,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,344,268.00	5,216,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,376,976.00	20,865,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,443,123.66	144,625,017.75
210301	Гэрэл, цахилгаан	8,124,279.56	10,797,917.95
210302	Түлш, халаалт	80,147,454.10	118,622,028.80
210303	Цэвэр, бохир ус	15,171,390.00	15,205,071.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,375,443.90	16,949,415.71
210401	Бичиг хэрэг	883,400.00	443,500.00
210402	Тээвэр, шатахуун	960,000.00	140,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,846,969.90	2,781,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,162,200.00	858,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,726,100.00	8,135,791.00
210408	Бараа материал акталсны зардал	6,796,774.00	4,590,924.71

2105	Нормативт зардал	131,711,260.00	136,937,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	94,900.00	182,400.00
210502	Хоол, хүнс	131,616,360.00	136,755,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,165,000.00	16,757,100.00
210604	Урсгал засвар	22,165,000.00	16,757,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,656,000.00	2,620,000.00
210701	Гадаад албан томилолт	1,136,000.00	1,600,000.00
210702	Дотоод албан томилолт	520,000.00	1,020,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,919,200.00	4,166,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,829,200.00	3,253,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,658,000.00	913,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,014,260.16	93,074,723.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,600,000.00	2,425,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,173,770.00	8,793,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,240,490.16	81,855,673.67
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,652,776.34	13,586,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,747,000.00	13,586,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,747,000.00	13,586,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,905,776.34	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	168,419,695.94	-242,558,072.07
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	139,282.30	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	139,282.30	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-139,282.30	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	168,280,413.64	-242,558,072.07

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,555,757,800.00	1,348,256,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,555,757,800.00	1,348,256,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,402,243,900.00	1,195,253,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,402,243,900.00	1,195,253,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	153,513,900.00	153,002,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	153,513,900.00	153,002,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,378,036,033.90	1,530,419,064.00

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,378,036,033.90	1,530,419,064.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,325,383,257.56	1,516,832,664.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	910,185,086.00	1,042,737,277.00
210101	Үндсэн цалин	555,640,888.00	641,528,731.00
210102	Нэмэгдэл	294,115,124.00	313,809,251.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,199,610.00	42,204,596.00
210104	Урамшуулал	51,229,464.00	45,194,699.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,022,848.00	129,751,600.00
210201	Тэтгэврийн даатгал	79,403,529.00	88,021,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,351,204.00	10,432,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,546,871.00	5,216,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,344,268.00	5,216,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,376,976.00	20,865,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,443,123.66	144,002,700.00
210301	Гэрэл, цахилгаан	8,124,279.56	10,797,917.95
210302	Түлш, халаалт	80,147,454.10	117,999,711.05
210303	Цэвэр, бохир ус	15,171,390.00	15,205,071.00
2105	Нормативт зардал	132,062,680.00	135,121,930.00
210502	Хоол, хүнс	132,062,680.00	135,121,930.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,165,000.00	9,000,000.00
210604	Урсгал засвар	22,165,000.00	9,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,046,000.00	3,814,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,046,000.00	3,814,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,458,519.90	52,405,157.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,043,419.90	40,552,757.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,415,100.00	11,852,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,652,776.34	13,586,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,747,000.00	13,586,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,747,000.00	13,586,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,905,776.34	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	177,721,766.10	-182,162,764.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,108,700.00	1,451,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,108,700.00	1,451,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,108,700.00	1,451,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,108,700.00	1,451,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-13,108,700.00	-1,451,500.00

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	164,613,066.10	-183,614,264.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	42,943,499.93	207,556,566.03
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	207,556,566.03	23,942,302.03

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/төгрөгөөр/
						Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,631,897.80	545,509,463.25	904,718,961.95	00.00	1,761,860,323.00
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,631,897.80	545,509,463.25	904,718,961.95	00.00	1,761,860,323.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	190,792.00	00.00	190,792.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	311,631,897.80	545,509,463.25	904,909,753.95	00.00	1,762,051,115.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-190,792.00	00.00	00.00	-190,792.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	242,558,072.07	00.00	-242,558,072.07
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,631,897.80	545,318,671.25	662,351,681.88	00.00	1,519,302,250.93

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/төгрөгөөр/ Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,396,933,000.00	1,378,867,864.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,396,933,000.00	1,378,867,864.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,383,346,600.00	1,365,281,464.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,043,248,200.00	1,042,737,277.00
210101	Үндсэн цалин	713,313,500.00	641,528,731.00
210102	Нэмэгдэл	294,907,800.00	313,809,251.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	42,204,596.00
210104	Урамшуулал	35,026,900.00	45,194,699.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,751,600.00	129,751,600.00
210201	Тэтгэврийн даатгал	88,021,600.00	88,021,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,432,400.00	10,432,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,216,300.00	5,216,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,216,300.00	5,216,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,865,000.00	20,865,000.00
2105	Нормативт зардал	149,178,300.00	135,121,930.00
210502	Хоол, хүнс	149,178,300.00	135,121,930.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,442,000.00	3,814,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,442,000.00	3,814,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54726500.00	53856657.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,824,600.00	41,954,757.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,901,900.00	11,901,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13586400.00	13586400.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,586,400.00	13,586,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,586,400.00	13,586,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,396,933,000.00	1,195,253,600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,203,213,200.00	1,195,253,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,203,213,200.00	1,195,253,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	193,719,800.00	00.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	193,719,800.00	00.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	207,556,566.03
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	23,942,302.03
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35.00	35.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00

2.6 АУДИТ ХИЙСЭН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
-----	----------	------------	-----------------------------	-----------------	------

1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	153,002,700.00	153,002,700.00		100.0%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	153,002,700.00	153,002,700.00		100.0%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	153,002,700.00	153,002,700.00		100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	144,002,700.00	144,002,700.00		100.0%
210301	Гэрэл цахилгаан	13,894,200.00	10,797,917.95	3.096.282605	77.7%
210302	Түлш, халаалт	84,572,700.00	117,999,711.05	-33.427.011605	139.5%
210303	Цэвэр, бохир ус	45,535,800.00	15,205,071.00	30.330.729.00	33.4%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,000,000.00	9,000,000.00		100.0%
210604	Урсгал засвар	9,000,000.00	9,000,000.00		100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	153,002,700.00	153,002,700.00		100%
1310	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	153,002,700.00	153,002,700.00		100%
132001	Орон нутгийн төсвөөс	153,002,700.00	153,002,700.00		100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35	35		100%
620001	Удирдах ажилтан	1	1		100%
620002	Гүйцэтгэх ажилтан	22	22		100%
620003	Үйлчлэх ажилтан	12	12		100%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Багшлахуй, суралцахуйг дэмжсэн сургалт, үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөн зохион байгуулах

Зорилт: 1. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зөвлөн тусалж, өдөр тутмын сургалт, үйл ажиллагааны чанарыг сайжруулах.

2. Мэргэжлийн багш нарын бүлгийн хамтын ажиллагааг өргөжүүлж, багшлахуйг дэмжсэн МХБ-ийн туршлагыг дэлгэрүүлэх.

3. Сургалт, үйл ажиллагааны явцын болон үр дүнгийн үнэлгээнд үндэслэн суралцахуйн хоцрогдлыг нөхөх, хоцрогдох магадлалтай суралцагчдад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж ахиц гаргах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улаангом сумын 3 дугаар цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ хадалдан авах тухай хууль
- Хэмнэлтийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Нийгмийн даатгалын ерөнхий хууль - 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдсөн
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 05 дугаар сарын 04-ний өдөр, 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 11 дүгээр сарын 10-ны өдөр, 12 дугаар сарын 07-ны өдөр, 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр
- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн бараа ажил үйлчилгээ худалда авах тухай хууль 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус тус шинэчлэн тогтоосон байна

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын 3 дугаар Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом сумын 3 дугаар Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 246,962.4 мянган төгрөгөөр буюу 14.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	207,556.6	23,942.3	-183.6
Авлага	0.00	0.00	0.00
Бараа материал	137,288.2	151,829.3	14.5
Үндсэн хөрөнгө	1,417,015.5	1,345,756.4	-71,259.2
Нийт хөрөнгө	1,761,860.3	1,521,527.9	-240,332.4
Өр төлбөр	0.00	2,225.7	2,225.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,761,860.3	1,519,302.2	-242,558.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,761,860.3	1,521,527.9	-240,332.4

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь өмнөх оны үзүүлэлтээс 183.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 151,829.3 мянган төгрөг болж 14.5 мянган төгрөгөөр өссөн нь худалдаж авсан бусад хангамжийн материалаас, шалтгаалжээ. Бараа материал дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл нь 2,225.7 мянган төгрөг болж нярайн чөлөөтэй байгаа ажилтнуудын байгууллага төлөх нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой өглөг үүссэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,345,756.4 мянган төгрөг болж 71,259.2 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь үндсэн хөрөнгийн тайлант хугацааны элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,519,302.2 мянган төгрөг болж 240,332.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,477,689.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 187,834.5 төгрөг нийт 1,665,523.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 114,993.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,203,213.2 мянга, орон нутгийн төсвөөс 153,002.7 мянга, нийт 1,356,215.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,195,253.6 мянга, урьд оны үлдэгдлээс санхүүжих 193,719.8 мянга, нийт 1,388,973.4 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 1,378,867.9 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд оны эхний үлдэгдлээс 13,836.8 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Орон нутгийн төсвөөс гүйцэтгэлээр 153,002.7 мянган төгрөгийн төсөв бүрдүүлж түлш, халаалтын зардалд 117,999.7 мянга, гэрэл цахилгааны зардалд 10,797.9 мянга, цэвэр бохир усны зардалд 15,205.1 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,531,870.6 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 510.9 мянга, нормативт зардлыг 14,056.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 2,628.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Эрүүл мэндийн дэмжих	2,653.7	2,253.7	0.00	100%
2	Хүүхдийн хоол	149,178.3	135,121.9	14,056.3	90.6%
3	Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	2,713.5	1,844.0	869.5	56%
4	Боловсролын стандарт, сургалтын орчин	5,383.0	5,383.0	0.00	100%
5	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	1,189,009.4	1,185,870.2	3,139.2	84.3%
6	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	45,105.7	45,105.6	0.1	99.3%
7	Хүүхэд хамгаалал	2,889.4	2,889.4	0.00	100%

8	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	15,002.7	15,002.7	0.00	100 %
---	---------------------------------------	----------	----------	------	-------

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамж	-	-	Байгууллагын үйл ажиллагаанд 300.0 мянган төгрөгийн программ ашиглаж байна.
2	Унаа,хоолны зардал	-	16,375.0	2025 онд унаа, хоолны зардалын төсөв гэж төсөвлөөгүй бөгөөд цалингийн зардалаас 16,375.0 мянган төгрөг олгосон.
3	Сургалт ,семинар	-	-	Тухайн байгууллага төсөвлөгдсөн зардал байхгүй .
4	Гадаад томилолт,арга хэмжээ	-	1.600.0	Гадаад томилолтын зардлын төсөвгүй бөгөөд гүйцэтгэлээр 1,600.0 мянган төгрөгийн гадаад томилолтын зардалд зарцуулжээ.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	-	-	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Хэвлэл мэдээлэл	-	-	Тайлант жилд хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ хийгээгүй.
7	Орон тоо	1,043,248.2	1,042,737.3	Улаангом сумын 3 дугаар Цэцэрлэг нь 2025 онд 35 орон тоотой үйл ажиллагаа явуулж 1,043,248.2 мянган төгрөгийн цалингийн зардал батлагдсанаас тайлант онд 1,042,737.3 мянган төгрөгийг ажилчдын цалин хөлс,урамшуулалд зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Улаангом сумын 3 дугаар Цэцэрлэгийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаангом сумын 3 дугаар Цэцэрлэгийн тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улаангом сумын 3 дугаар цэцэрлэг нь хүүхдийн хоолны шууд худалдан авалтыг 6 багц бүтээгдэхүүнд 135,121.9 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдөр tender.gov.mn цахим хуудсанд байршуулан худалдан авалтыг зохион байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын 3 дугаар Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян жанжин хишиг аудит ХХК-ийн туслах аудитор Г.Тунгалаг гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ч.Мөнхтогтох, аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын 3 дугаар Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян жанжин хишиг аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 16-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,281,631.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,816.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,602,809.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 16,028.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 12,822.0 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Улаангом сумын 3 дугаар Цэцэрлэгийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 169 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Улаангом сумын 3 дугаар Цэцэрлэгт 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улаангом сумын 3 дугаар Цэцэрлэгийн хувьд дараагийн аудитаар анхаарах чухал асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн												

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ
ХХК-ийн ЗАХИРАЛ, АУДИТОР

(Signature)

/А.ДУГАРМАА/

2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр

12

13

14

15

16

17

18

19